



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШУА-ИЙН ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/191/СТА-ТШЗ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2018 он



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:
Монгол Улсын Үндэсний Аудитын газар
Засгийн газрын IY байр Улаанбаатар-
46 Бага тойруу 6
Web: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг

Утас: 261663
И-мэйл: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 261885
И-мэйл: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж
Утас: 261740
И-мэйл: tserendorjd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Пантер мидланд аудит” ХХК

И-мэйл: info@pma.mn
Утас: 70141770
Захирал: Д.Билэгсайхан
Утас: 94111770
И-мэйл: bilegsaikhan.d@pma.mn

Аудитын багийн ахлагч:
Аудитор: А.Долгор
Утас: 99171199
И-мэйл: aa_dolgor.@yahoo.com

АУДИТЫН ТАЙЛАН

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн
санхүүгийн тайлан

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Агуулга

| | |
|--|----|
| Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл | 1 |
| Байгууллагын хууль эрх зүйн орчин | 2 |
| Байгууллагын зорилго, үйл ажиллагаа | 3 |
| Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн | 4 |
| Материаллаг байдал | 5 |
| Дотоод хяналт | 6 |
| Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар | 7 |
| Шилэн дансны мэдээлэл | 8 |
| Олж тогтоосон гол эрсдлүүд | 9 |
| Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар | 10 |
| Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар | 11 |
| Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар | 12 |
| Анхаарал татахуйц бусад чухал асуудал | 13 |
| Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд | 14 |
| Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл | 15 |
| Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 16 |
| Дүгнэлт | 17 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

САГ-2018/191/СТА-ТШЗ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Оршил

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу Хэл зохиолын хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд “Пантер мидланд аудит” ХХК гэрээгээр аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хуулийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулав.

Хэл зохиолын хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэл зохиолын хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дугаар сарын 25-нээс 2017 оны 2 дугаар сарын 23-ны хооронд “Пантер мидланд аудит” ХХК аудит хийхээр төлөвлөв. /ТАБ-СТА-А-9/



САГ-/2018/191/СТА-ТШЗ



Хэл зохиолын хүрээлэн нь 2017 оны санхүүгийн тайланг 2017 оны 02 дүгээр сарын 05 -нд, Төрийн сангаар хянуулсан төсвийн гүйцэтгэлийн тайланг 02 дугаар сарын 06-нд “Пантер мидланд аудит” ХХК-нд хугацаа хоцроож ирүүлсэн байна.

“Пантер мидланд аудит” ХХК нь жилийн эцсийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 25-нд Хэл зохиолын хүрээлэнгийн удирдлагад танилцуулна.

2. Байгууллагын хууль эрх зүйн орчин:

Хэл зохиолын хүрээлэнгийн удирдлага нь Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлангийн хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн нь 1921 онд “Судар бичгийн хүрээлэн”-гийн дэргэд “Дуун ухааны тасаг” нэртэйгээр байгуулагдсан бөгөөд “Монгол хэл, утга соёлын судлалыг олон улсын монгол судлалын түвшинд хүргэх” эрхэм зорилгын дор Шинжлэх ухааны академийн эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол хэлний бүтэц, тогтолцоо, хэв шинжийн судалгаа
- Монгол аман ба бичгийн утга зохиолын туурвил зүйн судалгаа


Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Өөрийн судалгааны тэргүүлэх чиглэлийнхээ дагуу суурь болон хавсарга судалгаа хийхийн зэрэгцээ төрөөс баримтлах хэлний бодлогыг хэрэгжүүлэх, бүх нийтийн хэлний боловсролыг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна.

Төсвийн захирагчтай шууд холбоотой Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашигласан болно.



САГ-/2018/191/СТА-ТШЗ



Аудитаар Хэл зохиолын хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн шууд захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, материаллаг дүнтэй зарим гүйлгээнүүдийг түүвэрчилсэн байдлаар аудитын 31 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Хэл зохиолын хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах, програмд нэвтрэх зэрэг аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэсэн болно. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, боловсруулах үйл ажиллагааг "Acolous" санхүүгийн програмыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан байна.

5. Материаллаг байдал

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг тооцохдоо 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн төсвийн орлогоор суурь үзүүлэлт болгон сонгож 2.0 хувиар буюу 12,670.6 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн шатанд 2017 оны нийт орлогын гүйцэтгэлийг суурь болгон сонгож мөн 2.0 хувиар 12,670.6 мянган төгрөгөөр сонгон авлаа.


6. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тохиолдох магадлалтай хяналтын эрсдэлүүдээс 5 данс хяналтын эрсдэлийг агуулж байж болзошгүй гэж тооцсон. /ТАБ-СТА-А-5.2-өөс үзнэ үү/

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Шинжлэх ухаан технологийн сан тус байгууллагын банкин дахь харилцах дансаар олгож, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэл, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна.

Хэл зохиолын хүрээлэнгийн үйл ажиллагааны төсөр 2017 онд 560,644.6 мянган төгрөгөөр батлагдсанаас 557,387.6 мянган төгрөгийн санхүүжилт авч төсвийг хэтрүүлээгүй байна.



Тайланд тусгасан бараа материал, үндсэн хөрөнгө нь бодитойгоор оршин байгаа ба байгууллагын өмчлөлд байгаа бүхий л өмч хөрөнгийг бүрэн хамруулж, орлого, зарлага болон шилжилт хөдөлгөөн, бусад зарлагын гүйлгээнүүд нь данс, дүн, хугацаа, ангиллын хувьд үнэн зөв бүртгэгдсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны цахим хуудас болох www.shilendans.gov.mn хуудсанд 2017 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл оруулсан байна.

Байгууллагын цахим хуудсанд байгууллагын мэдээллүүд, 2017 оны төсвийн гүйцэтгэлийг оруулсан байна. Байгууллагын самбараар дамжуулан төсөв, төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг суралцагсад болон иргэдэд нээлттэй хүргэж байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 21 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 31 горим, сорил гүйцэтгэж доорх эрсдэлүүдийг олж тогтоов. /ТАБ-СТА-В-3-аас үзнэ үү/ Үүнд:

Ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн захирамжаар олгох нөхөн төлбөрийг төсвийн санхүүжилтээр цалингийн зардлаас гаргаж барагдуулсан.

Ажилтны амралтын олговор тооцох дундаж цалинд хоол, унааны мөнгийг оруулж тооцсон.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

1.Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 101/ШШ2017/03516 тоот захирамжаар ажилтанд ажлаас үндэслэлгүй халагдаж ажилгүй байсан хугацааны цалин 4,366.0 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр цалингийн зардлаас гаргаж барагдуулсан байна.

2.Улсын Их Хурлын 2017 оны 67 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлийг үндэслэн төсвөөс 15,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 2017 онд ажилласан 54 ажилтанд 13,825.0 мянган төгрөг олгож 1,175.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

САГ-/2018/191/СТА-ТШЗ

4

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

11. Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтуудад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээтэй алдаа зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байсан ба холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

1. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 101/ШШ2017/03516 тоот захирамжаар ажилтанд ажлаас халагдаж ажилгүй байсан хугацааны цалин 4,366.0 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилт цалингийн зардлаас гаргаж барагдуулсан нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийг үндэслэн ажиллагсдын 2017 оны ээлжийн амралтын элговрыг бодож олгохдоо цалингийн бүрэлдэхүүнд хоол унааны мөнгийг оруулан дундаж цалинг тооцож 1,281.8 мянган төгрөг илүү олгосон нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 3/а-д “Цалин хөлсний бүрэлдэхүүн хэсгийг дараах байдлаар ойлгож хэрэглэнэ. Үүнд: “Үндсэн цалин гэж ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг гүйцэтгэсний төлөө ажил олгогчоос ажилтанд олгох баталгаат хөлсийг хэлнэ”.


Үндсэн цалинд хийснээр болон цагаар тарифт цалин, албан тушаалын цалин, ажлын онцлог, ажилтны онцгой ур чадварыг үндэслэн контракт болон хөдөлмөрийн гэрээгээр тусгайлан тохирсон цалин, тэдгээртэй адилтгах хэлбэрээр тогтоосон бусад баталгаат хөлс хамаарна” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажиллагсдын ээлжийн амралтын дундаж цалинг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын дагуу тооцож байх албан шаардлага хүргүүлэв.

3. Хангамжийн материалын 486.8 мянган төгрөгийг, гүйлгээг шаардах хуудасгүй, зарлагын падангүйгээр зарлага болгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”. 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, Сангийн сайдын

САГ-/2018/191/СТА-ТШЗ

5



2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх зааврын 3.6-д "Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн Шаардах хуудас 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал үнэ бүхий зүйлсийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан зааврыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

4. Аудитын горимын дагуу 18 нэр төрлийн 12,181.3 мянган төгрөгийн номыг түүвэрлэн тоолоход 91.7 мянган төгрөгийн зөрүү гарсан ба агуулахын эмх цэгц муу, номыг төрөлжүүлж байрлуулаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулж, удирдах" гэж заасныг зөрчсөн ба, Санхүүгийн тайлангийн оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх, агуулахын эмх цэгцийг сайжруулж номыг төрөлжүүлэн байрлуулж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

5. Жилийн эцсийн санхүүгийн тайланг Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн газарт 01 дүгээр сарын 19-нд тайлагнасан боловч аудитын байгууллагад 02 дугаар сарын 05-нд ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж... гэж заасныг зөрчсөн байна.


Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.

Залруулагдаагүй алдаа байхгүй.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад асуудал байгаагүй болно.



14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Санхүүгийн тайлангаар эргэлтийн номын үлдэгдэл 54,240.5 мянган төгрөг байна. Эргэлтийн номын үлдэгдэл бодитоор оршин байгаа байдлыг дахин авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Хэл зохиолын хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 6,196.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба дээрх зөрчил нь материаллагын түвшингээс бага байгаа болно.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн 2016 оны санхүүгийн тайланд “Бэст фортуна Аудит” ХХК аудит хийж 3 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.


17. Зөрчилгүй санал дүгнэлт

Хэл зохиолын хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгуудад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



САГ-/2018/191/СТА-ТШЗ

7



Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн удирдлагад зориулан бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг танай байгууллагын бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан Хэл зохиолын хүрээлэнгийн удирдлага болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

САГ-/2018/191/СТА-ТШЗ

8

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудитын ажиглалт

1. Хангамжийн материалын 486.8 мянган төгрөгийн гүйлгээг шаардах хуудасгүй, зарлагын падангүйгээр зарлага болгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3 дах заалт “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”. 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх зааврын 3.6 -д “Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн Шаардах хуудас 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал үнэ бүхий зүйлсийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Аудитын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 08 дугаар сарын 1-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ****01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2. Аудитын горимын дагуу 18 нэр төрлийн 12,181.3 мянган төгрөгийн номыг түүвэрлэн тоолоход 91.7 мянган төгрөгийн зөрүү гарсан ба агуулахын эмх цэгц муу, номыг төрөлжүүлж байрлуулаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулж, удирдах” гэж заасныг зөрчсөн ба, Санхүүгийн тайлангийн оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэл

Материалын зардал буруу тодорхойлогдох, өмч хөрөнгө шамшигдах

(Оршин байх, үнэн зөв байх)

Үйлчлүүлэгчийн хариу

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллана.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

САГ-/2018/191/СТА-ТШЗ

10

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

ШУА "ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН"
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| ҮЗҮҮЛЭЛТ | 2016.12.31 | 2017.12.31 |
|--|-----------------------|-----------------------|
| МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | - | - |
| Банкинд байгаа бэлэн мөнгө | - | - |
| Төгрөг | - | - |
| Төрийн сангийн харилцах | - | - |
| АВЛАГА | 25,219,145.00 | 2,450,000.00 |
| Татаас санхүүжилтийн авлага | 7,086,060.00 | |
| Бусад авлага | 18,133,085.00 | 2,450,000.00 |
| Байгууллагаас авах авлага | 18,133,085.00 | 2,450,000.00 |
| БАРАА МАТЕРИАЛ | 59,735,699.27 | 69,024,127.41 |
| Хангамжийн материал | 59,735,699.27 | 69,024,127.41 |
| Бичиг хэргийн материал | 3,390,550.28 | 4,259,300.00 |
| Аж ахуйн материал | 11,388,393.00 | 10,524,333.50 |
| Ном | 44,956,755.99 | 54,240,493.91 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 84,954,844.27 | 71,474,127.41 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | 167,991,509.37 | 138,819,542.44 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 167,991,509.37 | 138,819,542.44 |
| Биет хөрөнгө | 167,043,675.96 | 138,113,708.95 |
| Барилга, байгууламж | | |
| Хуримтлагдсан элэгдэл | | |
| Авто-тээврийн хэрэгсэл | | |
| Хуримтлагдсан элэгдэл | | |
| Машин, тоног төхөөрөмж | 211,446,183.07 | 215,196,183.07 |
| Хуримтлагдсан элэгдэл | (95,942,009.48) | (128,083,894.63) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 54,293,086.51 | 55,962,636.51 |
| Хуримтлагдсан элэгдэл | (38,715,817.05) | (41,981,448.91) |
| Түүх соёлын дурсгалт зүйлс | 825,230.00 | 825,230.00 |
| Номын фонд | 34,147,003.03 | 35,205,003.03 |
| Бусад үндсэн хөрөнгө | 989,999.88 | 989,999.88 |
| Биет бус хөрөнгө | 947,833.41 | 705,833.49 |
| Програм хангамж | 2,210,000.00 | 2,210,000.00 |
| Хасагдуулга | (1,262,166.59) | (1,504,166.51) |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 252,946,353.64 | 210,293,669.85 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | | 3,828,956.72 |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | | 3,828,956.72 |
| Өглөг | - | 3,828,956.72 |
| Ажиллагчидтай холбогдсон өглөг | - | 1,438,791.72 |
| Байгууллагад өгөх | | 2,390,165.00 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН | 252,946,353.64 | 206,464,713.13 |
| Засгийн газрын хувь оролцоо | 252,946,353.64 | 206,464,713.13 |
| Засгийн газрын оруулсан капитал | 612,660,425.89 | 612,660,425.89 |
| Хуримтлагдсан үр дүн | (366,057,472.62) | (412,539,113.13) |
| Өмнөх үеийн үр дүн | (366,057,472.62) | (366,057,472.62) |
| Тайлант үеийн үр дүн | | (46,481,640.51) |
| Дахин үнэлгээний зөрүү | 6,343,400.37 | 6,343,400.37 |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН | 252,946,353.64 | 210,293,669.85 |

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ШУА "ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН"
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| ҮЗҮҮЛЭЛТ | 2016.12.31 | 2017.12.31 |
|---|-----------------------|-----------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО | | |
| ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 647,218,460.00 | 624,927,590.00 |
| Улсын төсвөөс | 647,218,460.00 | 556,144,600.00 |
| Урсгал | | 556,144,600.00 |
| Нийгмийн даатгалын сангаас | 595,768,600.00 | |
| Нэмэлт санхүүжилтийн орлогоос | 51,449,860.00 | 68,782,990.00 |
| Бусад төсөвт байгууллагаас | | |
| Хөрөнгийн | | |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс | 44,449,860.00 | |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан | 7,000,000.00 | 64,972,000.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд | | 3,810,990.00 |
| БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | 10,190,000.00 | 8,600,797.40 |
| Өмчийн орлого | | |
| Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 10,190,000.00 | |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 4,590,000.00 | 4,499,997.40 |
| Үнэ төлбөргүй орлого | 5,600,000.00 | 4,100,800.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 657,408,460.00 | 633,528,387.40 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 655,325,119.90 | 680,010,027.91 |
| АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ | 547,362,477.32 | 530,133,863.30 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 493,779,611.52 | 476,666,000.00 |
| Цалин | 462,300,160.52 | 390,000,000.00 |
| Нэмэгдэл цалин | 31,479,451.00 | 65,120,000.00 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | | 21,546,000.00 |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | 53,582,865.80 | 53,467,863.30 |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 43,834,629.42 | 44,897,065.86 |
| Тэтгэврийн даатгалын шимтгэл | 34,065,269.50 | 34,656,420.65 |
| Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,698,385.98 | 4,556,813.00 |
| ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,869,447.32 | 3,918,674.00 |
| Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,201,526.62 | 1,765,158.21 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 9,748,236.38 | 8,570,797.44 |
| БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ | | |
| Хангамж, бараа материалын зардал | 1,457,225.34 | 2,098,674.73 |
| Бичиг хэргийн материал | 78,000.00 | |
| Бараа материал акталсны | | 871,320.00 |
| Шуудан холбооны зардал | 1,114,225.34 | 949,854.73 |
| Ном, хэвлэлийн зардал | 265,000.00 | 277,500.00 |
| Норматив зардал | - | 114,750.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 114,750.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | | 6,570,999.95 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | | 70,999.95 |
| Урсгал засвар | | 6,500,000.00 |
| Томилолт, зочны зардал | 4,959,900.00 | 4,377,000.00 |
| Дотоод томилолтын зардал | 2,184,900.00 | 4,377,000.00 |
| Гадаадын зочны зардал | 2,775,000.00 | |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | |
|---|-----------------------|-----------------------|
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төрөл | 32,918,396.00 | 79,626,379.85 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг | 31,418,396.00 | 79,626,379.85 |
| Аудит баталгаажуулалтын зардал | 1,500,000.00 | |
| Улсын мэдээллийн маягтын зардал | | |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 67,578,998.56 | 39,999,444.26 |
| Бусад зардал | 31,856,711.00 | 4,349,927.33 |
| Элэгдлийн зардал | 35,722,287.56 | 35,649,516.93 |
| Урсгал шилжүүлэг | 1,048,122.68 | 17,088,915.82 |
| Төвлөрүүлэн шилжүүлэг | 1,048,122.68 | 3,263,915.82 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 13,825,000.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 654,276,997.22 | 680,010,027.91 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 2,083,340.10 | -46,481,640.51 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО | - | - |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит) | - | - |
| Үндсэн хөрөнгө худалдсаны олз | - | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV) | - | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | - | - |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит) | - | - |
| Хөрөнгө худалдсаны гарз | - | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | - | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 2,083,340.10 | -46,481,640.51 |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**ШУА "ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН"
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

| ҮЗҮҮЛЭЛТ | 2016.12.31 | 2017.12.31 |
|--|-----------------------|-----------------------|
| ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 654,824,733.00 | 635,247,686.00 |
| Улсын төсвөөс | 595,768,600.00 | 556,144,600.00 |
| Урсгал | 595,768,600.00 | 556,144,600.00 |
| Хөрөнгийн | | |
| Орон нутгийн төсвөөс | | |
| Бусад төсөвт байгууллагаас | | |
| Нийгмийн даатгалын сангаас | 7,606,273.00 | 3,234,036.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 51,449,860.00 | 75,869,050.00 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан | 44,449,860.00 | 7,086,060.00 |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан | 7,000,000.00 | 64,972,000.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд | | 3,810,990.00 |
| БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | 5,667,520.00 | 4,499,997.40 |
| Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 4,590,000.00 | 4,499,997.40 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 4,590,000.00 | 4,499,997.40 |
| Туслах үйл ажиллагааны орлого | 1,077,520.00 | |
| Нэр, данс зөрүүгийн орлого | | |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 660,492,253.00 | 639,747,683.40 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 653,749,267.00 | 618,350,767.58 |
| АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ | 554,968,750.32 | 531,929,107.58 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 501,385,884.52 | 479,900,036.00 |
| Цалин | 501,385,884.52 | 393,234,036.00 |
| Нэмэгдэл цалин | | 65,120,000.00 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | | 21,546,000.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 53,582,865.80 | 52,029,071.58 |
| Тэтгэвэрийн даатгалын шимтгэл | 34,065,269.50 | 34,651,307.36 |
| Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,698,385.98 | 4,269,290.00 |
| ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4,869,447.32 | 3,560,255.00 |
| Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1,201,526.62 | 1,694,262.21 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 9,748,236.38 | 7,853,957.01 |
| БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ | 2,962,000.00 | 1,896,400.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 2,962,000.00 | 1,896,400.00 |
| Бичиг хэргийн материал | 424,400.00 | 368,247.89 |
| Шуудан холбоо, интернэтийн зардал | 734100 | 949,854.73 |
| Ном, хэвлэлийн зардал | 1,265,000.00 | 277,500.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 538,500.00 | 300,797.38 |
| Нормативт зардал | 200,000.00 | 198,000.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | 198,000.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 52,100.00 | 6,609,400.00 |
| Багаж, техник хэрэгсэл | 52,100.00 | 59,400.00 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | | 50,000.00 |
| Урсгал засвар | | 6,500,000.00 |
| Томилолт, зочны зардал | 6,241,200.00 | 3,320,700.00 |
| Дотоод албан томилолт | 3,241,200.00 | 3,320,700.00 |
| Зочин, төлөөлөгч хүлээн авах | 3,000,000.00 | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 47,181,874.00 | 70,137,160.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээ | 45,681,874.00 | 70,137,160.00 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,500,000.00 | |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЭЛТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЭЛТ

| | | |
|---|-----------------------|-----------------------|
| Бараа ажил үйлчилгээний бусад зардал | 42,143,342.68 | 4,260,000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 34,009,160.00 | 4,260,000.00 |
| Төвлөрүүлэн шилжүүлэг | 8,134,182.68 | |
| Урсгал шилжүүлэг | | 17,088,915.82 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 13,825,000.00 |
| Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| Төвлөрүүлэн шилжүүлэг | | 3,263,915.82 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II) | 653,749,267.00 | 635,439,683.40 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II) | 6,742,986.00 | 4,308,000.00 |
| Хөрөнгийн орлого | | |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| Бусад хөрөнгө борлуулсны орлого | | |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | | |
| Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал | 6,743,000.00 | 4,308,000.00 |
| Хөрөнгийн бусад зардал | | |
| Гарсан зардлаа дансны нэгдсэн жагсаалтаас авах | | |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V) | 6,743,000.00 | 4,308,000.00 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(4)=(4)-(V) | (6,743,000.00) | (4,308,000.00) |
| САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| Авсан зээл | | |
| Төлсөн зээл | | |
| САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ДҮН(8) | | |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII) | 6,742,986.00 | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

15

**ШУА "ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН"
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2017.12.31

| Д/Д | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---|---------------------------------|-----------------------|-------------------------|--|
| 1 | 2016 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 612,660,425.89 | 6,343,400.37 | (368,140,812.72) | 250,863,013.54 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 612,660,425.89 | 6,343,400.37 | (368,140,812.72) | 250,863,013.54 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| 5 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| 9 | 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 612,660,425.89 | 6,343,400.37 | (366,057,472.62) | 252,946,353.64 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 11 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 612,660,425.89 | 6,343,400.37 | (366,057,472.62) | 252,946,353.64 |
| 12 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| 14 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 15 | Тайлант үеийн үр дүн | - | - | (46,481,640.51) | (46,481,640.51) |
| 16 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 612,660,425.89 | 6,343,400.37 | (412,539,113.13) | 206,464,713.13 |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**ШУА "ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН"
АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2017 он

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Сарын гүйцэтгэл | Хувь |
|--|-----------------------|-----------------------|---------------------|-------------|
| Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл | - | | - | |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V) | 560,644,600.00 | 557,387,631.58 | 3,256,968.42 | 99% |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 560,644,600.00 | 557,387,631.58 | 3,256,968.42 | 99% |
| Бараа ажил үйлчилгээний зардал | 545,644,600.00 | 543,562,631.58 | 2,081,968.42 | 100% |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 476,666,000.00 | 476,666,000.00 | - | 100% |
| Үндсэн цалин | 390,000,000.00 | 390,000,000.00 | - | 100% |
| Нэмэгдэл | 65,120,000.00 | 65,120,000.00 | - | 100% |
| Унаа,болон бусад нөхөн олговор | 21,546,000.00 | 21,546,000.00 | - | 100% |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54,083,200.00 | 52,029,071.58 | 2,054,128.42 | 96% |
| Тэтгэвэрийн даатгалын | 34,396,913.00 | 34,651,307.36 | (254,394.36) | 101% |
| Тэтгэмжийн даатгалын | 4,841,768.00 | 4,269,290.00 | 572,478.00 | 88% |
| ҮОМШ өвчний даатгалын | 4,018,879.00 | 3,560,255.00 | 458,624.00 | 89% |
| Ажилгүйдлийн даатгалын | 973,502.00 | 1,694,262.21 | (720,760.21) | 174% |
| Байгууллага төлөх ЭМД -ийн хураамж | 9,852,138.00 | 7,853,957.01 | 1,998,180.99 | 80% |
| Хангамж, бараа материалын зардал | 1,954,400.00 | 1,954,400.00 | - | 100% |
| Бичиг хэргийн материал | 654,400.00 | 368,247.89 | 286,152.11 | 56% |
| Хог хаягдал устгах цэвэрлэх | 100,000.00 | | 100,000.00 | 0% |
| Шуудан холбоо, интернэтийн зардал | 720,000.00 | 949,854.73 | (229,854.73) | 132% |
| Ном, хэвлэлийн зардал | 380,000.00 | 335,500.00 | 44,500.00 | 88% |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 100,000.00 | 300,797.38 | (200,797.38) | 301% |
| Нормативт зардал | 198,000.00 | 198,000.00 | - | 100% |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 198,000.00 | 198,000.00 | - | 100% |
| Эд хогшил худалдан авах | 6,550,000.00 | 6,550,000.00 | - | 100% |
| Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 50,000.00 | 50,000.00 | - | 100% |
| Урсгал засвар | 6,500,000.00 | 6,500,000.00 | - | 100% |
| Томилолт, зочны зардал | - | - | - | |
| Дотоод албан томилолт | | | - | |
| Зочин, төлөөлөгч хүлээн авах | | | - | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 5,693,000.00 | 5,665,160.00 | 27,840.00 | 100% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамж | 5,673,000.00 | 5,665,160.00 | 7,840.00 | 100% |
| Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 20,000.00 | | 20,000.00 | 0% |
| Бараа ажил үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 500,000.00 | - | 100% |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 | 500,000.00 | - | 100% |
| Урсгал шилжүүлэг | 15,000,000.00 | 13,825,000.00 | 1,175,000.00 | 92% |
| Бусад урсгал шилжүүлэг | 15,000,000.00 | 13,825,000.00 | 1,175,000.00 | 92% |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,000,000.00 | 13,825,000.00 | 1,175,000.00 | 92% |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 560,644,600.00 | 557,387,631.58 | 3,256,968.42 | 99% |
| Улсын төсвөөс санхүүжих | 556,144,600.00 | 552,887,634.18 | 3,256,965.82 | 99% |
| Улсын төсвөөс санхүүжих | 556,144,600.00 | 552,887,634.18 | 3,256,965.82 | 99% |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 4,500,000.00 | 4,499,997.40 | 2.60 | 100% |

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАМ ДҮГНЭЭТ**

| | | | | |
|--|--------------|--------------|------|------|
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,500,000.00 | 4,499,997.40 | 2.60 | 100% |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - | - | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | - | |
| Байгууллагын тоо | | | - | |
| Ажиллагсадын тоо | 50 | 50 | - | 100% |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100% |
| Гүйцэтгэх ажилтан | 49 | 49 | - | 100% |
| Суралцагсад / жилийн дунджаар / | | | - | |
| Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад | | - | | |
| Орон тооны мэдээлэл | 50 | 50 | - | 100% |
| ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮШУ/ | 46 | 46 | - | 100% |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч | 4 | 4 | - | 100% |

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**